



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: У.Батчимэг Утас: 88094175 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр).....	4
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	6
5.1 Зөвлөмж.....	6
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.15 № 2/108

танай _____-ны № _____-т

МЯНГАН-УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ЦАГААНЗОЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянган Угалзат ОНӨААТҮГ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгуулагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан баталуулж ажиллаагүй,
- Авлага барагдуулан ажиллах ажил зохион байгуулан ажиллаагүй,
- Өр төлбөр үүсгэн ажилласан зөрчил илэрлээ.

Асуудлыг онцолсон хэсэг

Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь зорилтот түвшинг батлаагүй байна.

Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5,906,350.2 мянган төгрөгийн балансын үнэтэй 5,795,006.9 мянган төгрөгийн элэгдлийн зардалтай нийтийн

эзэмшлийн хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын даргын 2024 оны 07 дугаар сарын 8-ны өдрийн дугаар А/59 захирамжаар шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 149,506.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****(төгрөгөөр)**

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,358,753.49	47,023,975.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	185,803.49	28,565.15
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	185,803.49	28,565.15
31210	Төгрөг	185,803.49	28,565.15
31213	Арилжааны банк дахь харилцах	185,803.49	28,565.15
33	АВЛАГА	21,818,350.00	21,818,350.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	21,583,502.00	21,583,502.00
33500	Бусад авлага	234,848.00	234,848.00
33510	Байгууллагаас авах авлага	234,848.00	234,848.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,354,600.00	25,177,060.00
35400	Хангамжийн материал	28,354,600.00	25,177,060.00
35420	Аж ахуйн материал	28,354,600.00	25,177,060.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	274,193,439.35	473,786,537.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	274,193,439.35	473,786,537.87
39200	Биет хөрөнгө	74,193,439.35	273,786,537.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,534,779.00	277,657,608.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,346,424.96	-153,377,872.13
39205	Машин тоног техөөрөмж(компьютер)	273,242,286.00	3,182,993,726.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-270,283,105.57	-3,172,590,924.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,098,640.00	87,546,440.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,245,709.57	-77,146,440.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,500,000.00	2,887,035,027.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,307,025.55	-2,758,331,027.00
39300	Биет бус хөрөнгө	200,000,000.00	200,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	200,000,000.00	200,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	324,552,192.84	520,810,513.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	205,774,094.66	133,342,350.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	205,774,094.66	133,342,350.92
41300	Өглөг	205,774,094.66	133,342,350.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,513,334.88	14,895,793.80
41360	Бусад өглөг	200,260,759.78	118,446,557.12
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	59,339,431.20	77,904,285.12
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	31,659,370.17	20,378,942.04
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	109,261,958.41	20,163,329.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	118,778,098.18	387,468,162.10
51	Засгийн газрын хувь оролцоо	118,778,098.18	387,468,162.10
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	559,038,740.00	559,038,740.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-697,919,533.89	-429,229,469.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-618,875,871.55	-384,371,172.00
51220	Тайлант үеийн үр дүн	-79,043,662.34	-44,858,297.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	257,658,892.07	257,658,892.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	324,552,192.84	520,810,513.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**(төгрөгөөр)**

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,333,610.10	13,637,827.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,333,610.10	13,637,827.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,333,610.10	13,637,827.00

120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	126,912,764.85	164,004,259.81
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	125,579,154.75	150,366,432.81
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,377,272.44	58,496,124.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,377,272.44	58,496,124.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,377,272.44	58,496,124.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,377,272.44	58,496,124.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,377,272.44	58,496,124.97
III	ЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-79,043,662.34	-44,858,297.97
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-79,043,662.34	-44,858,297.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	139,604,041.34	180,404,634.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	139,604,041.34	180,404,634.18
120	Нийтлэг татварын бус орлого	139,604,041.34	180,404,634.18
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	139,604,041.34	180,404,634.18
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	139,466,188.81	180,561,872.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	139,466,188.81	180,561,872.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,466,188.81	180,561,872.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,031,312.49	146,996,801.75
210101	Үндсэн цалин	77,031,312.49	146,996,801.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,489,000.00	0
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	5,489,000.00	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,838,873.30	2,979,019.49
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	23,838,873.30	2,979,019.49
2104	Хангамж, бараа материалын зардал	10,560,456.50	19,796,400.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	7,950,547.00	3,300,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	2,609,909.50	16,496,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,546,546.52	10,789,651.28
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,622,790.91	0
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	20,923,755.61	10,789,651.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	137,852.53	-157,238.34
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	137,852.53	-157,238.34
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,950.96	185,803.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	185,803.49	28,565.15

2.4 Аудит хийсэн өмч өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн

1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,038,740.00	308,206,206.00	-414,339,810.82	452,905,135.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-204,536,060.73	204,536,060.73
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,038,740.00	308,206,206.00	-618,875,871.55	248,369,074.45
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-50,547,313.93	0	50,547,313.93
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-79,043,662.34	79,043,662.34
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,038,740.00	257,658,892.07	-697,919,533.89	118,778,098.18
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,038,740.00	257,658,892.07	-697,919,533.89	118,778,098.18
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,038,740.00	257,658,892.07	-697,919,533.89	118,778,098.18
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	313,548,361.89	313,548,361.89
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-44,858,297.97	44,858,297.97
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	559,038,740.00	257,658,892.07	-429,229,469.97	387,468,162.10

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,342.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 133,342.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 133,342.3 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1.1. Өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын хуримтлагдсан өр төлбөр нь материаллаг дүнтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Мянган-Угалзат ОНӨААТҮГ	Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллаагүй,	1	133,342.3					1	133,342.3		
	ДҮН	1	133,342.3			-	-	1	133,342.3		